



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/227

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төр засагтаа хөдөлмөрөө үнэлүүлж Улсын аварга малчин, тариаланчаар шалгарсан нэр бүхий 12 иргэнд өргөмжлөлийн зардалд 1,720,165 төгрөг, Алтан төлийн эзнээр шалгарсан нэр бүхий 3 иргэнд өргөмжлөлийн зардалд 312,400 төгрөг, Монгол Улсын гавьяат цолоор шагнагдсан З.Тоня, Б.Жамсран нарыг угтан авах арга хэмжээний зардалд 630,500 төгрөг, Тагнуулын газрын дарга Анхбаяр нь өөр аймагт шилжин ажиллаж байгаа тул дэмжлэгийн зардалд 360,000 төгрөг, “Соёл урлагтай амьдралаа холбосон 40 жил” хүндэтгэлийн тоглолт зохион байгуулсан Халтайн Цэрэнбадамд өргөмжлөлийн зардалд 120,000 төгрөг, Азийн аварга Буяндалайд өргөмжлөлийн зардалд 180,000 төгрөг, Улсын тэргүүний Ахмадын хороогоор шалгарсан Мянгад сумын Ахмадын холбоонд батламж хийлгэх зардалд 137,125 төгрөг, Эрүүл мэндийн салбарын оны шилдэг эмч нарын өргөмжлөлийн зардалд 295,000 төгрөг, Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шинэ байрны нээлтэнд өргөмжлөл хийлгэсэн зардалд 75,000 төгрөгийг тус тус баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 3,830,190 төгрөг (гурван сая найман зуун гучин мянга нэг зуун ер)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



3400 01 1113
Zah A/227 Kh